



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/05

Чингис хот

Арга хэмжээг зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 оны 3 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах "ITM-2020" Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд "Түнш аймаг" –аар оролцох арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Г.Хэрлэнчулуун	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичиг	Б.Мөнхжаргал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Мэргэжилтэн
Гишүүд	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Д.Цогт-Эрдэнэ	Хан Хэнтий чуулгын дарга
	Н.Нямсүрэн	Музейн захирал
	Б.Баясгалан	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

2. Үзэсгэлэнгийн ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, зохион байгуулж оролцохыг ажлын хэсгийн ахлагч /Г.Хэрлэнчулуун/ -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010033